



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/02/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123</p> <p>Ахлах аудитор: Г.Оюунболд Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
Байгууллагын үйл ажилагаа.....	10
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.2.1 Витумын тогоо худалдан авсан баримт байгаа боловч биетээр байхгүйд төлбөрийн акт тогтоосон.....	13
4.2.2 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 135
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ЗАМ ЗАСВАР
АРЧЛАЛТЫН "ТАЛЫН ЗАМ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. ТҮВШИНМӨНХ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Талын зам ТӨХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Талын зам ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Санхүүгийн байдлын тайлан

" ТАЛЫН-ЗАМ" ТӨХК Байгууллагын нэр		төгрөгөөр	
Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1. ХӨРӨНГӨ			
1.1. Эргэлтийн хөрөнгө			
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	61,912,726.63	1,733,883.57	
1.1.2. Дансны авлага	42,935,492.24	151,648,997.21	
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	0.09	0.00	
1.1.4. Бусад авлага			
1.1.5. Бусад санхүүгийн хөрөнгө			
1.1.6. Бара материал	244,605,941.40	210,673,737.51	
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	0.00	0.00	
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө			
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтйн бус хөрөнгө			
1.1.11. Эргэлтйн хөрөнгийн дүн	349,454,160.37	364,056,618.28	
1.2. Эргэлтийн бус хөрөнгө			
1.2.1. Үндсэн хөрөнгө	1,015,210,491.02	930,811,674.14	
1.2.2. Биет бус хөрөнгө	224,150,000.00	217,375,000.00	
1.2.3. Биологийн хөрөнгө			
1.2.4. Урт хугацаат хөрөнгө оруулалт			
1.2.5. Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			
1.2.6. Хойшлогдсон татварын хөрөнгө			
1.2.7. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
1.2.8. Бусад эргэлтийн бус хөрөнгө			
1.2.12. Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,239,360,491.02	1,148,186,674.14	
1.3. НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,588,814,651.39	1,512,243,292.42	
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
2.1 Өр төлбөр			
2.1.1 Богино хугацаат өр төлбөр			
2.1.1.1. Дансны өглөг	731,995.98	18,721,925.88	
2.1.1.2. Цалингийн өглөг	0.00	0.01	
2.1.1.3. Татварын өр	25,861,982.59	84,887,350.48	
2.1.1.4. НДШ-ийн өр	0.00	0.00	
2.1.1.5. Банкны богино хугацаат зээл			
2.1.1.6. Хүүний өглөг			
2.1.1.7. Ногдол ашгийн өглөг			
2.1.1.8. Урьдчилж орсон орлого	0.00	0.00	
2.1.1.9. Нөөц өр төлбөр			
2.1.1.10. Бусад богино хугацаат өр төлбөр			
2.1.1.11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам			
2.1.1.13. Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,593,978.58	103,609,276.37	
2.1.2 Урт хугацаат өр төлбөр			
2.1.2.1. Урт хугацаат зээл			
2.1.2.2. Нөөц өр төлбөр			
2.1.2.3. Хойшлогдсон татварын өр			
2.1.2.4. Бусад урт хугацаат өр төлбөр	21,445,411.00	21,445,411.00	
2.1.2.6. Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,445,411.00	21,445,411.00	
2.2 Өр төлбөрийн нийт дүн	48,039,389.58	125,054,687.37	
2.3 Эздийн өмч			
2.3.1 Төрийн	1,144,365,089.34	1,148,115,089.34	
2.3.2 Хувийн			
2.3.3 Хувьцаат			
2.3.4 Халаасны хувьцаа			
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал			
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	242,135,306.17	242,135,306.17	

2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	224,150,000.00	224,150,000.00
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-69,875,133.69	-227,211,790.47
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,540,775,261.82	1,387,188,605.04
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,588,814,651.39	1,512,243,292.42

Захирал / Б.ТҮВШИНМӨНХ /
 Нягтлан бодогч / Б.ГАНБОЛОР /



2.2 Аудит хийсэн орлогын тайлан

Орлогын дэлгэрэнгүй тайлан

(2021/01/01 - 2022/01/01)

" ТАЛЫН-ЗАМ" ТӨХК

Байгууллагын нэр

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	938,090,368.52	1,130,606,886.34
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	680,171,166.65	909,492,995.63
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	42,628,610.26	75,707,816.87
Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг	637,542,556.39	833,785,178.76
3. Нийт ашиг (алдагдал)	257,919,201.87	221,113,890.71
4. Түрээсийн орлого		
5. Хүүний орлого	75,219.76	
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	983,590.91	27,667,272.73
9. Борлуулалт, маркетингийн зардал	64,027,422.67	82,361,138.79
10. Ерөнхий ба удирдлагын зардал	185,495,649.74	191,237,033.78
11. Санхүүгийн зардал		74,699.41
12. Бусад зардал	6,666,127.73	4,596,634.36
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,788,812.39	(29,488,342.90)
19. Орлогын татварын зардал	278,881.24	
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	2,509,931.15	(29,488,342.90)
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,509,931.15	(29,488,342.90)
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	2,509,931.15	(29,488,342.90)
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Захирал Б. ТҮВШИНМӨНХ
 Нягтлан бодогч Б. ГАНБОЛОР



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

" ТАЛЫН-ЗАМ" ТӨХК

(2021/01/01 - 2022/01/01)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,144,365,089.34			242,135,306.17		224,150,000.00	-69,875,133.69	1,540,775,261.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							-29,488,342.90	-29,488,342.90
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт	3,750,000.00						-128,099,313.88	-124,349,313.88
7	Зарласан ногдол ашиг							251,000.00	251,000.00
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн								
9	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,148,115,089.34			242,135,306.17		224,150,000.00	-227,211,790.47	1,387,188,605.04

Захирал

Ерөнхий нягтлан бодогч



Б.ТҮВШИНМӨНХ

Б.ГАНБОЛОР

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээний тайлан

(2021/01/01 - 2022/01/01)

" ТАЛЫН-ЗАМ" ТӨХК

Байгууллагын нэр

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,221,469,366.15	1,201,201,709.45
1.1 Мөнгөн орлогын дүн	1,221,469,366.15	1,201,201,709.45
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		53,880,081.82
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	1,221,469,366.15	1,147,321,627.63
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,048,977,123.31	1,255,471,507.06
Ажиллагчдад төлсөн	237,093,682.38	283,404,400.01
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	76,203,402.35	94,237,001.70
Бараа материал худалдан авахад төлсөн	537,742,728.78	768,528,238.81
Ашиглалтын зардал төлсөн	114,748.00	2,015,141.16
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		18,222,556.37
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгуулгад төлсөн	115,641,302.53	33,713,673.43
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	82,181,259.27	55,350,495.58
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	172,492,242.84	- 54,269,797.61
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	115,420,090.91	5,658,000.00
Мөнгөн орлогын дүн		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн	115,420,090.91	5,658,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	115,420,090.91	5,658,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	115,420,090.91	- 5,658,000.00
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	840,000.00	251,000.00
Мөнгөн орлогын дүн		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн	840,000.00	251,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	840,000.00	- 251,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	287,072,333.75	60,178,797.61
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,648,668.78	61,912,726.63
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	61,912,726.63	1,733,883.57
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		

Захирал Б. ТҮВШИНМӨНХ
 Нягтлан бодогч Б. ГАНБОЛОР



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Талын зам ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Талын зам ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өөрийн хариуцсан А2001 Өндөрхаан Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай автозамыг нүхэн эвдрэлгүй байлгах, тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийх гэсэн үндсэн зорилт, хөрөнгө оруулалтаар хийх ажлыг чанартай гүйцэтгэх гэсэн дэд зорилт дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Талын зам ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1187.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажиллагаа

Талын зам ТӨХК-ийн зорилго нь хариуцсан А2001 Өндөрхаан Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай автозамыг нүхэн эвдрэлгүй байлгах, тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийх гэсэн үндсэн зорилт оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, засвар арчлалт гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд автозам, замын байгууламжийг засвар арчлалт статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Талын зам ТӨХК нь Сайд нарын 1987 оны 163 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Талын зам ТӨХК-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн /ТУЗ-ын 9 гишүүний цалин нийт/ цалин, урамшууллыг 2.28 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд бүртгэлийг сайжруулахаар 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж санхүүгийн программыг шинэчлэх арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар

хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 34 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 29 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 2.0 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Талын зам ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	61912.7	1733.8	-60178.9
БХХО			
Авлага	42935.5	151648.9	108713.4
Урьдчилгаа			
Бараа материал	244605.9	210673.7	-33932.2
Үндсэн хөрөнгө	1015210.5	930811.6	-84398.9
Биет бус хөрөнгө	224150.0	217375.0	-6775.0
Нийт хөрөнгийн дүн	1588814.6	1512243.3	-76571.3
Өр төлбөрийн дүн	48039.4	125054.6	77015.2
Богино хугацаат өглөг	26593.9	103609.2	77015.2
Урт хугацаат өглөг	21445.4	21445.4	
Эздийн өмч	1144365.0	1148115.0	3750.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1588814.6	1512243.2	-76571.3

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.2 сая төгрөг, банкин дахь мөнгөний үлдэгдэл харилцах дансанд байгаа 1.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд Аймгийн ЗДТГ-аас 47.4 сая төгрөг, Андын илч ХХК-аас 74.0 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаас үүссэн байгууллагаас авах авлага 121.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 121.4 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 27.6 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 210.6 сая төгрөг болж 33.9 сая төгрөгөөр буурсан нь дуусаагүй үйлдвэрлэл буюу хөрөнгө оруулалтад зарцуулсан материал буурсан нь шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 1515.2 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 3,8 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь тухайн хөрөнгийг орлогод аваад ашигласан тухай бүрд өртөг зардалд шингээж зарлагадаагүйгээс бараа материалын дансанд дээр 1-ээс дээш жил хөдөлгөөн ороогүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 2.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд хөрөнгө элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 103,6 сая төгрөгийн өр төлбөр байна. Энэ нь НӨАТ-ийн төлөгдөөгүй өрийн үлдэгдэл болон техник түрээсийн өглөгийн үлдэгдэл байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2009 онд Кувейтын сангийн хөрөнгөөр санхүүжигдэн зам засварын компаниудад тараагдсан механизмуудын 21,4 сая төгрөгийн зээл байна. Уг өглөг нь эргэн төлөх нөхцөл, хувиар огт байхгүй байгаагаас урт хугацаат өр төлбөр дансанд хөдөлгөөнгүй олон жил болсон байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 29,1% буюу 246,8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн тендер болон хөрөнгө оруулалтын ажлууд авч гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Талын зам ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Талын зам ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 633 дугаар тушаалаар “Талын зам” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 983,6 сая төгрөгөөр, нийт зардлыг 966,8 сая төгрөгөөр, 15,1 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 16,6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1 158,3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1 187,8 сая төгрөгийн зардал гарган, 29,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1 158,3 сая төгрөг болж төлөвлөснөөс 174,7 сая төгрөг буюу 17 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1 187,8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 221,0 сая төгрөг буюу 22 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 29,5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 44,6 сая төгрөгөөр дутуу байгаа нь техник, түрээсийн зардал өндөр гарсан нь нөлөөлсөн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Талын зам ТӨХК-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн дотоод хяналт байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Харилцагч байгууллагаас нэхэмжилсэн 71.3 сая төгрөгийн зам засварын асфалтийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Уг төлбөрийг хуулийн байгууллагын шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайланд тусгах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.2.1 Витумын тогоо худалдан авсан баримт байгаа боловч биетээр байхгүйд төлбөрийн акт тогтоосон.

4.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Өгсөн зөвлөмж:

1 Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Талын зам ТӨХК	1	6.6			1	6.6				
Дүн											
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн											